

Хэлц ба хэлц бус холбоо үг

Хичээлийн зорилго

- Хэлц ба хэлц бус холбоо үг гэж юу вэ? Түүний ангилал онцлог шинжийг мэдэх .
- Ялгаатай талыг мэдэх
/ чөлөөт чөлөөт бус холбоо үг /
- Хэлц бус холбоо үгийн цөм дагуул үгийг мэдэх

Хичээлийн зорилт

- Хэлц бус холбоо үгийн цөм , дагуул үгийг ялгаж сурах
- Хэлц холбоо үгийг зөв олж таних
- Өгүүлбэрт холбоо үгийг оновчтой сонгон найруулан бичих

Холбоо үг

Хэлц холбоо үг

Хэлц бус холбоо үг



Хэлц холбоо үг

- ❖ Холбоо үгийг бүтээж байгаа хэсгүүд нийлээд нэг гишүүн болно
- ❖ Үг бүр нь үндсэн утгаа гээж нийлээд нэг утга илтгэнэ.
- ❖ Дүрслэх ур маягаар бүтдэг
- ❖ Нийгмийн шинжтэй
- ❖ Орчуулахад хүнд, утга алдагддаг

Хэлц бус холбоо үг

- ⦿ **Хоёр гишүүнт бүтэцтэй/** холбоо үгийг бүтээж байгаа хэсгүүд өөр өөр гишүүн болно /
- ⦿ **Дагуул үг+цөм үг** гэсэн бүтэцтэй.
- ⦿ Үг тус бүр нь бие даасан утгатай
- ⦿ Дүрслэх ур маягаар бүтэхгүй
- ⦿ Хувь хүний шинжтэй
- ⦿ Орчуулахад хялбар

Хэлц холбоо үг

Хэлц холбоо үгийг утгаар нь

- ❖ Утгазүйжсэн холбоо үг
- ❖ Үгийн санжсан холбоо үг
- ❖ Бүхэлзүйжсэн холбоо үг
- ❖ Хэлзүйжсэн холбоо үг

ангилдаг.

Утгазүйжсэн холбоо үг

- Шууд бус утгатай
- Дүрслэх ур маягаар бүтнэ, салаа утгатай
- Түүхэн уламжлал, монгол ахуйн сэтгэхүйн өвөрмөц онцлогийг тусгасан байдаг.
- Дүрслэл сайтай тул баймж утга илтгэдэг.

Утгазүйжсэн холбоо үгийн жишээ

Усан тэнэг, морин шарилж, хонин тогоо, шанаган хорхой, загасан талх, хурган бантан, дээлийн гол, үхэр бүрээ, шалзан хадаас, хорхой ааруул, ямаан омог, ноён нуруу, тэмээн аалз, тарваган шийр, торгон элс, ганзага нийлэх, морин зөгий гэх мэт .

Үгийн санжсан холбоо үг

- Нэг утга илтгэдэг
- Дүрслэх ур маягаар бүтээгүй, салаа утгагүй , шууд утгатай
- Нэр томъёоны шинжтэй байна

Үгийн санжсан холбоо үгийн жишээ

Морин тэрэг, үхэр тэрэг, морин хуур,
тосон будаг, усан будаг, бор шувуу, хөх
яргуй, усан үзэм, чулуун зэвсэг, шар
шувуу, цагаан будаа, төмөр зам, могойн
чуулган, гар тээрэм, гэрэл зураг, их
хурал, гангар гунгар, усан мандал, сүлд
дуулал, үнэртэй ус гэх мэт.

Бүхэлзүйжсэн холбоо үг

- ◎ Аль нэг нь ерөнхий , нөгөө нь тодорхой утгыг илтгэнэ
- ◎ Нэг нь нөгөөгөө орлож болдог
- ◎ Нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй
- ◎ Эцсийнх нь өмнөхөө тодотгоно

Бүхэлзүйжсэн холбоо үгийн жишээ

тэд бүгдээр, тогос шувуу, таван жил,
хөгшин амьтан, хятад маяг, иргэн
Саруул, Дорж багш, нөхөр Бат, хүн
та, энэ үлгэр, тэр уул, Өэлүн эх,
тэр гурав, олон хүн, бүх хүүхэд,
бид хоёр, хэдэн адуу, боодол цаас,
тэд цөм, бид бүгдээр , тэр нөхөр,
ЭНЭ НОХОЙ ГЭХ МЭТ.

Хэлзүйжсэн холбоо үг

- Аль нэг нь үгийн сангийн утгаа гээж хэлзүйн хийсвэр утга илтгэнэ
- Аль нэг нь туслах үүрэгтэй
- Баймж утга илтгэнэ
- Үндэс язгуурыг бүрэн ба бүрэн бус давтдаг.
- Бай, бол , билээ зэрэг туслах үйл үг, мөн орон цагийн нэртэй нийлж бүтэж болох төдийгүй зарим үйл үг туслах үүргээр орж, хэлзүйжсэн холбоо үгийг бүтээдэг.

Хэлзүйжсэн холбоо үгийн жишээ

Зөвшөөрч болно, үзэх хэрэгтэй, хүрч
очих, тэнгэрээс доогуур, модноос
дээгүүр, өвөр дээрээ, модон дунд,
толгойн чинээ, айхын цагт, мэдэх ёстой,
дасах хэрэгтэй, суудлын хооронд,
хүлээж бай, байж болно, сурахын тулд,
гэрийн хойно, яван явсаар, ув улаан,
маш сайн, алсын алсад гэх мэт.

Хэлц бус холбоо үг

Хэлц бус холбоо үгийг цөм үг буюу голлосон үгээр нь

- **Нэрийн холбоо үг**
- **Үйлийн холбоо үг гэж ангилдаг.**

Хэлц бус холбоо үг / чөлөөт холбоо үг/

Хэлц бус холбоо үг нь
Дагуул үг + цөм үг гэсэн бүтэцтэй
байдаг.

Жнь: номин тал, сувдан зүүлт,
алсаас харах, кино үзэх, хичээл
давтах, шүлэг цээжлэх, ахын ном
,сурагчийн цүнх, ангийн булан ,
бичиг бичих гэх мэт .

Нэрийн холбоо үг

Захирч байгаа үг нь нэр үг байвал нэрийн холбоо үг болно.

Жнь: түүхийн дэвтэр , эгчийн ном, нарны туяа, төмөр хүрз, өндөр байшин

Үйлийн холбоо үг

Захирч байгаа үг нь үйл үг байвал үйлийн холбоо үг болно.

Жнь: морь унах, гэр барих, зураг зурах, захиа бичих, шатар тоглох, хоол идэх , хичээл хийх ГЭХ МЭТ.